

Товьёг

Д/д	Товч утга	Хуудасны тоо	Хуудасны дугаар
1	Улсын Их хурлын тогтоол	1	2-3
2	УИХ-ын байнгын хорооны тогтоол	1	3-4
3	Засгийн газрын тогтоол	4	4-8
4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	8-13
5	Ерөнхий сайдын албан даалгавар, захирамж	1	13-24
6	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	1	24-26

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Орхон аймаг Нийгмийн даатгалын газар

2025.12.10

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
1	2	3	4	5	6	7	8
Улсын Их Хурлын тогтоол							
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024.04.18	2	Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	Тус газрын Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор шинээр батлагдан гарсан хууль, журам тогтоол шийдвэрүүдийг өөрийн байгууллагын онцлог, чиг үүрэгтэй уялдуулан жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, харилцаа хандлагыг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор сургалт арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: - “Ёс зүйгээрээ манлайлагч хэлтэс” болзолт уралдаан - “Бид соёлыг бүтээнэ, бид соёлыг түгээнэ” Нөлөөллийн арга хэмжээ - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээ, танин	100%		

				мэдэхүйн ойлголт өгөх зорилготой Хөгжөөнт тоглоом - Ёс зүйн тухай ойлголт рийл - “Ёс зүйтэй хариуцлагатай төрийн алба” “Та өгөхгүй бид авахгүй” пост - Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах хяналт тавих, идэвхжүүлэх зорилгоор “Өглөөг өөдрөг эхлүүлье” арга хэмжээг тус тус зохион байгуулсан.			
УИХ-ын Байнгын хорооны тогтоол							
1.	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай №6, 2024.11.06	1.3	Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Тус газрын Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор шинээр батлагдан гарсан хууль, журам тогтоол шийдвэрүүдийг өөрийн байгууллагын онцлог, чиг үүрэгтэй уялдуулан жилийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ төлөвлөн ажилласан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын байдлаар 86% хувийн биелэлттэй байна. Ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль эрх зүйн мэдлэг олгохоос гадна Шинэ үеийн даатгуулагчдын онцлогийг судалж түүний үндсэн дээр "Үйлчлүүлэгчтэй харилцах ёс зүйн хэм хэмжээ" сургалтыг 2 удаа зохион байгуулж 31 албан хаагчийг хамруулсан. Мөн танхимын сургалтаас гадна байгууллагын цахим хуудсыг ашиглан төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргах шалтгаан нөхцөлөөс урьдчилан сэргийлж сануулах, анхааруулах, сэргийлэх утга агуулга бүхий пост 12, рийл бичлэг 2 удаа оруулж ажилласан. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр тайлагнан ажиллаж	100%		

				Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийг хөтлөн, улирал бүр дээд шатны байгууллагад мэдээлэл хүргэж ажилласан.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Засгийн газрын тогтоол							
1.	Журам батлах тухай Дугаар 422 2023.11.29	1.1-7.2	“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох санхүүжүүлэх журам”	ЗГ-ын 2023 оны 11 сарын 29-ний өдрийн Дугаар 422 журмын дагуу ҮОМШӨ-ний даатгалын сангаас даатгуулагчид сэргээн засах төв болон сувиллыг зардлын төлбөрт 145 хүнд 116 сая төгрөг, унааны зардалд 4 хүнд 286,2 мянган төгрөгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж олгосон. Протез, ортопедын төлбөр авах хүсэлт ирээгүй байна.	100%		
2.	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай Дугаар 217 2024.12.18	2.2	Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2024 оноос эхлэн Нийгмийн даатгалын цогц систем болох https://portal.ndaatgal.mn/ -ийг ашиглаж байгаа бөгөөд Орхон аймгийн Нийгмийн даатгалд бүртгэлтэй 1362 ажил олгогчоос, давхардсан тоогоор 15,874 удаагийн шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авсан байна. Мөн 23,822 албан журмын даатгуулагчийн 279,538 удаагийн мэдээллийг Portal.ndaatgal.mn цахим системээр дамжуулан хүлээн авч регистрийн дугаар, иргэний бүртгэлийн дугаар, татвар төлөгчийн дугаар, гадаадын иргэний бүртгэлийн дугаараар шалган, баталгаажуулалт хийсэн. Иргэд даатгуулагчид болон ажил олгогчид дээрх системд Танилт нэвтрэлтийн DAN	100%		

				системээр нэвтэрч нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ авах боломж бүрдсэн.			
3.	Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай №163 тогтоол 2024.11.13	2	Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд "Able" программыг нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд Хүний нөөц, албан бичиг солилцоо, ажлын цаг бүртгэл, хурал, тушаал шийдвэр, архивын лавлагаа, олон нийтийн зар гэсэн хэсгүүдээс бүрдсэн цогц системийг ашиглаж байна. Мөн Орхон аймгийн хэмжээнд И-оффисс системийг албан бичиг солилцоо, өргөдөл хүсэлт хүлээж авах, хүний нөөцийн систем, ажлын цаг бүртгэл, тогтоол шийдвэрийн хэрэгжилт бүртгэх тайлагнах гэх мэт үйл ажиллагаанд бүрэн ашиглаж байна. Бичиг хэргийн ажилтан Б.Номин-Эрдэнэ нэмэлт	100%		
4.	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай №109 2024.10.02	2	Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай	Ёс зүйн дэд хорооны гишүүн Л.Эрдэнэсүвд МУ-ын Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" батлах тухай 109 дүгээр тогтоолыг албан хаагчдад танилцуулж, Тогтоол гарсантай холбогдуулан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан тухай сургалт, мэдээллийг Хүний нөөц хуулийн мэргэжилтэн Д.Идэржавхлан ажилтан албан хаагчдад танилцуулж ажилласан. Сургалтад нийт ТЗ-ны болон	100%		

				ТҮ-ний 29 ажилтан албан хаагчийг хамруулсан.			
5.	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай №196 2024.05.08	3	"Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	ХНУМТ цахим системд ажилтан албан хаагчдын Ерөнхий мэдээллийг бүрэн гүйцэт оруулах, ажилласан жилийг НД-ын шимтгэл төлөлтийн мэдээлэлтэй тулгах, ажил эрхлэлтийн түүхийг зөв оруулсан эсэхийг хянах, шагналын болон бусад мэдээллийг бүрэн гүйцэт оруулах ажлуудыг үе шаттайгаар хийсэн. Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа https://www.csc.gov.mn/ -ийн Төрийн албан хаагчийн портал цэсээр нэвтэрч албан хаагчид өөрсдийн мэдээллээ бүрэн баталгаажуулж дууссан. 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Хүний нөөцийн системд албан хаагчдын АТТ-ын холбох ажил явагдаж дууссан. АЗДТГ-аас Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн урьдчилсан үзлэгээр Хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд хангалттай үнэлгээ авсан.	100%		
6	Ажил амралтын цагийн зохицуулалтын тухай 2025.02.26 №109	1,2	Монголын үндэсний цагаан сарын баяр тасарч шинийн 2, 3- өдөр Бямба, ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 03,04,05-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарагт ажилтан албан хаагчдыг амрааж 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүр	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/71 тоот тушаалаар нөхөж ажилласан.	100%		

			шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.				
7	Ажил амралтын цагийн зохицуулалтын тухай 2025.06.04 №279	1,2	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12,13-ны өдөр Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва Пүрэв гарагт албан хаагчдыг амрааж 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүр шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийх тухай Засгийн газрын 2025 оны 279 дүгээр тогтоол гарсны дагуу Нийгмийн даатгалын газар нь дээрх хугацааны ажлын өдрийг урьдчилж буюу 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд ажилласан болно. 07 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд ажиллах болсон тухай 2025.07.04-ны өдрийн №377 албан тоотоор АЗДТГ болон НДЕГ-т мэдэгдсэн.	100%		
8	Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025.08.20 №52	4.3	Ерөнхий газар болон аймаг нийслэл, сум, дүүрэгт салбар нэгжтэй агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийг газар, газар нь дотороо хэлтэстэй, хэлтэс нь дотороо тасаг албагүй байхаар өөрчлөн зохион байгуулах	Тус газрын Бүтэц орон тоог НДЕГ-ын даргын 2025 оны А/239 тоот тушаалаар шинэчлэн баталж Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллийн тасгийг буулгаж Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэстэй нэгтгэн зохион байгуулсан.	100%		

9.	Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025.10.29 №147		Томуу томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, өвчний хүндрэлээс сэргийлэх зорилгоор 2025.11.01-2026.03.01-ний өдөр хүртэл хугацаанд томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа эцэг эх, асран хамгаалагчид ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгохыг төсвийн байгууллагын дарга захирал нарт даалгаж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын ажил олгогч нарт уриалсугай.	2025.11.10-ны өдрийн 09 цагийн байгууллагын нийт ажилтнуудын "мэдээллийн цаг" дээр Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн Д.Идэржавхлан Засгийн газрын 2025 оны 147 дугаар тогтоолыг байгууллагын удирдлагууд болон албан хаагчдад танилцуулж ажилласан. 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насний хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа эцэг, эх гараагүй байна.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
1.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл	10.19.4.2.	Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд,	1.ГБХНХСайдын 2025.02.25-ны өдрийн Шилэн дансны тухай хууль болон холбогдох хууль журмыг хэрэгжүүлэн ажиллах тухай 03 дугаар албан даалгаврын дагуу улирал бүр мэдээллээ байршуулан ажиллаж байна. Үнэлгээний хувь 97.6% үнэлэгдсэн. 2. Монгол улсын Ерөнхий сайдын 2025.03.07-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын 1.4 хэсэгт заасны дагуу тус байгууллагын хэрэгжүүлсэн 9-“тэргүүн туршлага”, мөн ISO9001:2015, ISO37001:2016 стандарт,	100%		

			аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	“Төрийн байгууллага сэтгэл зүйн дархлаатай байх арга замыг эрэлхийлэх нь” гэх мэт төсөл арга хэмжээг танилцуулж харилцан туршлага солилцсон. Мөн 1.6 дахь хэсэгт заасны дагуу иргэд аж ахуй нэгж байгууллагын өргөдөл хүсэлтийг шуурхай шийдвэрлэж 12 дугаар сарын байдлаар 350 өргөдөл хүсэлтийг хүлээн авсан байна. Өргөдлийг эцсийн байдлаар шийдвэрлэж хариу өгсөн 322 буюу 92% байна. Шийдвэрлэх шатандаа явж буй 28 өргөдөл буюу 8% эзэлж байна. 3. НДЕГ-ын даргын 2025.03.14-ны өдрийн 01 албан даалгаврын дагуу 4 зорилт 23 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан улирал бүр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			
2	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл	1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд бүрэн байршуулахыг Яамдын төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгов.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан цахим хуудсанд нээлттэй мэдээлэл байршуулах НДЕГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын веб сайт болон мэдээллийн самбарт байршуулах 48 нэр төрлийн мэдээллийг тогтмол шинэчлэн, хөтөлж Shilen.gov.mn сайтад нээлттэй мэдээллээ байршуулан 3-р улиралд 99.36% тай үнэлгээ авсан. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас https://e-mongolia.mn/ -д өөрийн байгууллагын мэдээллээ оруулан 4-р улирлыг дүгнүүлэхэд бэлтгэн ажиллаж байна.	100%		
3	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09	3	Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн	https://orhon.ndaatgal.mn/ Мэдээллийн цахим системийн ил тод байдлын өргөдөл	100%		

	дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл		мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгов.	гомдлын хэсэгт сар бүрийн өргөдөл гомдлын тайлан мэдээг оруулж хэвшсэн.			
4	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дугаар хуралдааны тэмдэглэл	1.	Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн 2024 он болон 2025 оны эхний хагас жилийн тайлан үнэлгээг байгууллагын цахим хуудсанд 2025.08.20-ны өдрийн дотор байршуулан олон нийтэд ил тод нээлттэй болгохыг Засгийн газрын агентлагийн дарга, аймаг нийслэлийн төрийн захиргааны бүх шатны байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгах.	Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн 2024 он болон 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээг байгууллагын цахим хуудсанд заасан хугацаан сканердаж бүрэн байршуулсан. https://orhon.ndaatgal.mn/	100%		
5	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэл	5.	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй шуурхай үзүүлэх цахимжуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх зорилгоор Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар фэйсбүүк, пэйж хуудсаараа дамжуулан энэ онд нийт 208 постер, 45 рийл бичлэг, 16 удаагийн шууд нэвтрүүлэг бэлтгэн 22,800 гаруй дагагч нарт нийгмийн даатгалын мэдээ, мэдээлэл хүргэсэн. Эдгээр мэдээлэл нь	100%		

				нийт 1,217,328 хандалтыг авсан байна. Төрийн албан хаагчдын ачааллыг бууруулах механик үйл ажиллагааг багасгах, иргэд цахим хувийн хэргээсээ мэдээллээ хэвлэж авах боломжийг бүрдүүлэх тэтгэврийн архивыг цахимжуулах хөтөлбөрийн хүрээнд 19 мянган тэтгэвэр авагчийн хувийн хэргийг цахимжуулах ажил үргэлжилж байна. Тэтгэврийн архивын өндөр насны тэтгэврийн 2025 оны байдлаар 5982 хувийн хэргийн 243426 ширхэг хуудсыг сканердаж цахим хувийн хэргийн программд бүртгэж оруулсан байна.			
6.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл.	3.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ил тод нээлттэй байхаар заасныг болон Төрийн болон албаны нууцын тухай хууль журмыг зөрчин үндэслэлгүйгээр нууцалсан мэдээллийг ил болгох ажлыг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны засаг дарга нар, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ил тод нээлттэй байхаар заасныг болон Төрийн болон албаны нууцын тухай хууль журмыг зөрчин үндэслэлгүйгээр нууцалсан мэдээлэл тус газарт байхгүй.	100%		
7	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10	2	Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн	https://www.gov.mn/-д Байгууллагын мэдээлэл, зорилго, зорилт, хаяг байршил, сошиал медиа, холбоо барих мэдээлэл	100%		

	дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл.		санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх	болон ил тод байдал хэсэгт улирал жилийн тайлан, үйл ажиллагааны, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдал мөн хууль эрх зүй, цаг үеийн мэдээ мэдээллийг оруулан orhon.ndaatgal.mn веб хуудасны линк холбон ажиллаж байна.			
8	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дугаар сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл.	7	7.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав.	2025 оны байдлаар Нийгмийн даатгалын газар нь Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгцээгүй худалдан авалт хийгээгүйгээс гадна, гадаад дотоод томилолтоор ажилласан албан хаагч байхгүй. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулаагүй, мөн ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллахыг зорин ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,722.7 мянган төгрөг зарцуулахаас 1,602.5 мянган төгрөгийг зарцуулж 120.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан.	100%		
9	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл	1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн, зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын төрийн нарийн бичгийн	Байгууллагын 48 мэдээллийг веб хуудас, фейсбүүк хаяг, мэдээллийн 6 самбарт байршуулсан мэдээлэлд улирал бүр хяналт тавьж, дутуу болон шинэчлэх шаардлагатай мэдээллийг залруулж, дараагийн шатны байгууллагаар улирал бүр дүгнүүлэн ажиллаж байна. Үнэлгээ авсан байдал: 1-р улирлын үнэлгээгээр 96% үнэлүүлсэн. 2-р улирлын үнэлгээгээр 99% үнэлүүлсэн. 3-р улирлын үнэлгээгээр 99% үнэлүүлсэн. 4-р улирлын үнэлгээ хүлээгдэж байна.	100%		

			дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт				
10	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл	39.29.12.3.	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	Орхон аймгийн Тагнуулын газраас зохион байгуулсан танхимын сургалтад Газрын даргын үүрэг гүйцэтгэгч, мэдээлэл технологийн мэргэжилтэн, нууц хамгаалах ажилтан оролцсон. Нийт ажилтан, албан хаагчидтай нууц хамгаалах гэрээ хийж ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтад тус газар багтдаггүй.	100%		
Хэсгийн дундаж: 100 хувь							
Ерөнхий сайдын албан даалгавар							
1.	“Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах бүтээмжийг сайжруулах тухай” 2025.06.18 №01	1.2	Төрийн бодлогын залгамж чанар тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах	Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу төрийн албаны хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн болон соён гэгээрүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байна. 2025 оны байдлаар тус газрын Ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 2 гомдол ирснийг Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасны дагуу судлан шинжилж дүгнэлт гаргаж ажилласан.	100%		

		1.3	Салбарын хэмжээнд сахилга хариуцлагыг өндөржүүлж, бүх шатны төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийг давхардалыг арилгаж орон тоог цөөлөх	Мөн байгууллагын хэмжээнд сахилга хариуцлагыг өндөржүүлж, төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах арга хэмжээг авч ажилласан. Төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгах, орон тоог цөөлөх тухай дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлж Газрын даргын 2025 оны А/32 дугаар тушаалаар байгууллагын бүтцийг шинэчлэн баталж 40 хүний орон тоог 36 болгон цөөлж Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллийн тасгийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэстэй нэгтгэн зохион байгуулсан.	100%		
		2.4	Авлига албан тушаалын гэмт хэргээс ангид ажиллаж хүнд суртал шударга бус байдалтай тууштэй тэмцэх, таслан зогсоох, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог идэвхжүүлэх	Тус газрын бүтэц орон тоо 36 болж цөөрсөнтэй холбогдуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу бүх ажилтанууд дунд нээлттэй санал хураалт явуулж Газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулсан. 2025 оны 12 дугаар сарын байдлаар Авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон ажилтан албан хаагч гараагүй. Албан хаагчдыг Авлига, ашиг сонирхолыг зөрчлөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын фейсбүүк хуудас, вэб хуудсаараа дамжуулан богино хэмжээний рийл, контентуудын тогтмол бэлтгэн хүргэж Авлига албан тушаалын гэмт хэргээс ангид ажилласан.	100%		

2		2.5	Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж чөлөөлөхгүй байх	Авлига албан тушаалын гэмт хэргээс ангид ажиллаж, хүнд суртал шударга бус байдалтай үл эвлэрэх зарчим барьж ажиллахыг нийт ажилтан албан хаагчдад үүрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж чөлөөлсөн шийдвэр гаргаагүй.	100%		
		2.6	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.	2025 оны байдлаар Нийгмийн даатгалын газар нь Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгцээгүй худалдан авалт хийгээгүйгээс гадна, гадаад дотоод томилолтоор ажилласан албан хаагч байхгүй. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулаагүй, мөн ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллахыг зорин ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,722.7 мянган төгрөг зарцуулахаас 1,602.5 мянган төгрөгийг зарцуулж 120.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан.	100%		
	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх	1.8	Бүс, орон нутгийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх;	Тус газар нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, залуучуудыг төрийн албанд бэлтгэх, нийгмийг соён гэгээрүүлэх үндсэн зорилгоор “Нийгмийн даатгалын төлөөлөгч” төсөл хөтөлбөрийг аймаг орон нутгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025 онд 5 ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/79 тоот захирамжаар төлөөлөгчдийн	100%		

	арга хэмжээний тухай 2025.03.07 №03	1.4	Бүс, орон нутгийнхаа сайн туршлага, шинэ санаачилга, инновац нэвтрүүлсэн туршлагыг олон нийтэд таниулах, түгээх, бусад аймаг, нийслэлтэй туршлага солилцох	цалинд 59.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 1.Монгол Улсын төрийн албаны зөвлөлөөс “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” Хойд бүсийн зөвлөгөөн Орхон аймагт зохион байгуулагдсан бөгөөд Тус зөвлөгөөнөөр Нийгмийн даатгалын газарт нэвтрүүлэн ажиллаж буй 9-н “Тэргүүн туршлага” танилцуулж оролцсон. 2. Мөн “Төрийн албаны реформ-бидний шийдэл” судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд “Төрийн байгууллага сэтгэл зүйн дархлаатай байх арга замыг эрэлхийлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлээр оролцсон бөгөөд тус Уралдаанд оролцсон илтгэлээ “Сэтгэл зүйн дархлаатай төрийн байгууллага” нэртэй төсөл болгон өргөжүүлж “Эдийн засгийн форум-2025” арга хэмжээнд төрийн байгууллагууд болон Олон улсын донор байгууллагуудад танилцуулж ажилласан. 3. Мөн нийгмийн даатгалын байгууллагын нэвтрүүлсэн Авлигын эсрэг стандарт ISO37001:2016, Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартуудыг төрийн болон хувийн хэвшлийн 10 гаруй байгууллагуудад танилцуулж туршлага судлан ажилласан.			
3	“Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025.07.25 №04	1.2	1.2 Төрийн албаны чиг үүргийн давхардалыг арилгаж, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй	Тус газар нь Ерөнхий сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа тушаал шийдвэр гаргаагүй бөгөөд 2025 оны байдлаар тэтгэвэрт гарсан албан хаагч болон төрийн албанаас чөлөөлөгдсөн албан	100%		

			байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн ажилтан, албан хаагчийн сул орон тоог царцааж нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад:	хаагчийн сул оронтоо гараагүй учир нөхөн томилгоо хийгдээгүй байна.			
		1.4	Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025.08.01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагуудад:	Нийгмийн даатгалын газрын ёс зүйн дэд хороо 2023 оноос 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 2025 онд бүтэц орон тоо шинэчлэн батлагдаж орон тоо 36 болсонтой холбогдуулан НДГ-ын даргын А/37 тоот тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүтэйгээр шинэчлэн байгуулсан.	100%		
		1.7	Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод	Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчийг чөлөөлөх, халах, аливаа шийдвэрийг гаргаагүй ажиллаж байна. Мөн хуулиар чиг үүрэгт өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн албан хаагчдыг чөлөөлөх халах албан тушаал бууруулах шилжүүлэх шийдвэр гаргахгүй байх гэсэн Ерөнхий сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%		

			заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;				
		1.8	Ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	МУ-ын Их хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор төрийн албаны шинэчлэлийг хийж, төрийн албаны тоог 9 хувиар бууруулах шийдвэр гарсны дагуу тус газар нь албан тушаалаас чөлөөлөгдөх албан хаагчийг бусад байгууллагад мэргэжлийн дагуу шилжүүлэх боломжийг судалж, зуучлах, тэдэнд дэмжлэг үзүүлэх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд 2025 оны 10 дугаар сарын 01-нээс ТҮ-ний 1 албан хаагчийг боловсролын байгууллагад, ТЗ-ны 1 албан хаагчийг мэргэжлийн дагуу орхон аймгийн ЭМД-ийн тасагт шилжүүлэн ажиллуулсан.	100%		
4.	Төрийн албаны сахилга, дэг журам хариуцлагыг чангатгах тухай 2025.07.08 №03	1.2	Харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн	Монгол улсын Их хурлын 2025 оны “Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 48 дугаар тогтоолоор төрийн албаны шинэчлэл хийж, чиг үүргийн давхардалыг арилган төрийн албан хаагчдын тоог 9 хувиар	100%		

			горимыг чанд мөрдөх, бүтэц чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх	бууруулах замаар чадварлаг цомхон бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх шийдвэр гарсаны дагуу тус газрын орон тоог 4 өөр бууруулж Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллийн тасгийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэст нэгтгэж газрын даргын 2025 оны А/32 тоот тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Үүний үндсэн дээр Төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоонд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан 3 албан хаагчийг ажлаас чөлөөлж, үндсэн орон тоонд ажиллаж байсан 2 албан хаагчийг төрийн бусад байгууллагад шилжүүлэн ажиллуулах замаар шийдвэрлэсэн.			
		1.6	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.	Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлан ажилласан. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, 2025 онд ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,722.7 мянган төгрөг зарцуулахаас 1,602.5 мянган төгрөгийг зарцуулж 120.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна. Гадаад дотоод томилолтоор ажилласан албан хаагч байхгүй.	100%		
		1.11	Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, харицлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг	Орхон аймгийн нийт иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын анхан шатны бүх үйлчилгээг Нэг цэгийн үйлчилгээгээр, шат дамжлагагүйгээр бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 22389 даатгуулагчид хүргэж	100%		

			бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх.	ажилласан. Нийгмийн даатгалын газрын фэйсбүүк пэйж хуудасны чатбот-оор дамжуулан нийт 855 хэрэглэгчдэд мэдээлэл зөвлөгөө өгсөн. Байгууллагын чатбот-оор дамжуулан тухайн иргэний үйлчилгээ авахад шаардагдах нийт 157 бичиг баримтыг цахимаар хүлээн авч шийдвэрлэж ажилласан. Даатгуулагч иргэдэд өдөр тутамдаа Callpro үйлчилгээ буюу утсаар мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг 75776699 лавлах утсанд иргэдээс ирсэн нийт 9438 /давхардсан тоогоор/ дуудлага ирснээс 8170 дуудлагад шууд хариу өгч 1268 дуудлага алдсан байна. Нийт алдагдсан дуудлагад эргэн холбогдож, шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Лавлах утсанд ирсэн дуудлагыг тог тасрах нэгэн зэрэг олон дуудлага ирэх зэрэг тохиолдолд дуудлага алдах тохиолдол гардаг. Энэ тохиолдолд алдсан дуудлага бүрд эргэж холбогддог. Хэрэв дуудлага аваагүй тохиолдолд хариуцсан байцаагчдын хувийн дугаарт шууд холбогдож иргэдэд чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж байна.			
		2.1	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ил тод нээлттэй байхаар заасныг болон Төрийн болон албаны нууцын тухай хууль журмыг зөрчин үндэслэлгүйгээр нууцалсан мэдээлэл тус газарт байхгүй.	100%		
		2.33	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн	Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу төрийн	100%		

			албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авилга, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулалан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн хороодыг байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх	албаны хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн болон соён гэгээрүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байна. 2025 оны байдлаар тус газрын Ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 2 гомдол ирсэнийг Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасны дагуу судлан шинжилж дүгнэлт гаргаж ажилласан. Мөн байгууллагын хэмжээнд сахилга хариуцлагыг өндөржүүлж, төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах арга хэмжээг авч ажилласан. Төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардалыг арилгах, орон тоог цөөлөх тухай дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлж Газрын даргын 2025 оны А/32 дугаар тушаалаар байгууллагын бүтцийг шинэчлэн баталж 40 хүний орон тоог 36 болгон цөөлж Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллийн тасгийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэстэй нэгтгэн зохион байгуулсан. Авлига албан тушаалын гэмт хэргээс ангид ажиллаж, хүнд суртал шударга бус байдалтай үл эвлэрэх зарчим барьж ажиллахыг нийт ажилтан албан хаагчдад үүрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж чөлөөлсөн шийдвэр гаргаагүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлан ажиллаж хэрэгцээгүй худалдан авалт болон гадаад дотоод томилолтоор ажиллуулсан албан хаагч байхгүй байна. 2025 онд Авлига ашиг сонирхолын зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй.		
--	--	--	---	--	--	--

		4.4	Ажилтны мэдлэг боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар Байцаагч, ажилтнуудыг чадавхжуулах дотоодын сургалтыг 104 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1284 албан хаагч хамрагдаж, 267072 хүн*цаг зарцуулан хүний нөөцийн хөгжил, ажилтны мэдлэг ур чадварт онцгой анхаарч ажилласан. Шинэ ажилтан бэлтгэх сургалтыг 4 удаа төлөвлөгөөний дагуу зохион байгуулж шинээр ажилд орж буй ажилтан, албан хаагч, байцаагч нарт нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдвэл зохих мэддлэгийг хүргэж ажилласан. Сургалтын дэлгэрэнгүй тайлан мэдээг дээд шатны байгууллагад хагас бүтэн жилээр хүргүүлэн ажиллаж байна. Мөн Хүн амын бүлгүүд Нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 6.600.000 төгрөгийн санхүүжилтийг аймаг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлж 16 албан хаагчийн Төрийн албаны мэргэшүүлэх сургалтад хамруулсан.			
5	ГБХНХСайдын “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” №03 2025.02.25	1.1-1.12	1.1 Яам агентлаг газар хэлтэс төвүүд болон холбогдох нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Шилэн дасны мэдээлэл байршуулахтай холбоотой арга хэмжээ тусгах	Шилэн дансны мэдээ байршуулах ҮА-ны нягтлан бодогч, Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнүүдийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Шилэн дасны мэдээлэл байршуулахтай холбоотой арга хэмжээ тусгаж гүйцэтгэлд хяналт тавих албан тушаалтнаар Захиргаа хяналтын хэлтсийн даргыг томилон ажиллуулж байна. Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсвийг Шилэн дансны тухай хуульд	100%		

			заасан хугацаанд байршуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 1 сарын 06-ны өдрийн А/01 тоот тушаалаар баталсан төсөв, 2025 оны 02 сарын 19-ны өдрийн А/15 тоот тушаал, 2025 оны 03 сарын 11-ний өдрийн А/50 тоот тушаал, 2025 оны 05 сарын 20-ны өдрийн А/143 тоот тушаал, 2025 оны 07 сарын 18-ны өдрийн А/201 тоот тушаал, 2025 оны 09 сарын 22-ны өдрийн А/227 тоот тушаалаар тус тус төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсныг тухай бүр байршуулсан. Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны 171 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн 149 мэдээлэл байршуулж, 1 мэдээлэл хоцорч байршуулсан. Нийгмийн даатгалын сангийн 159 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн 141 мэдээллийг байршуулсан. Нийт 290 мэдээллийг байршуулж, 1 мэдээллийг хоцроож хугацаандаа 99,6% байршуулан хэрэгжүүлэн ажиллаж, цахим хуудсанд тайланг улирал бүр мэдээлсэн. Шилэн дансны цахим хуудсанд тавих хяналтыг улирал бүр хийж, шалгалтын явцад мэдээллийн үнэн зөв бүрэн бүтэн оруулсан байдлыг шалгахад илүү мэдээлсэн 13 гүйлгээний 9,228.5 сая төгрөгийн мэдээллийг засаж, дутуу мэдээлсэн 24 гүйлгээний 14,207.9 сая төгрөгийн гүйлгээг нөхөн байршуулж нийт 37 гүйлгээний 23,436.4 сая төгрөгийн			
--	--	--	---	--	--	--

				гүйлгээний зөрчлийг арилгаж 100% хэрэгжүүлэн ажилласан.			
Монгол улсын ерөнхий сайдын захирамж							
1	Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025.08.13 №64	5	Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайл, ил тод байдлыг бэхжүүлэн бүх шатанд шударга ёсыг эрхэмлэж авлига, албан тушаалтны гэмт хэрэг, ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл сум дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай:	Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 64 дүгээр захирамжийг байгууллагын удирдлагын зүгээс бүх албан хаагчдад танилцуулж бүх шатанд шударга ёсыг эрхэмлэж авлига, албан тушаалтны гэмт хэрэг, ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллахыг үүрэг болгож ажилласан. 2025 оны 12 дугаар сарын байдлаар Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчид авилга ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол							
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоол	02	“Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам”	Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох шалгаруулалтын дагуу тэнцсэн нэр бүхий 4 рашаан сувилалд хэвтэн эмчлүүлсэн ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авдаг 229 хүний 185,3 сая төгрөгийн сувиллын зардлыг олгосон бол 12 хүний 885600 төгрөгийн унааны зардлыг олгоод байна.	100%		
2	Нийгмийн даатгалын үндэсний		“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан	“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах,	100%		

	зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоол	07	сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”	санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу НДЕГ-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 3 арга хэмжээний хүрээнд сургалт зохион байгуулах төсвийн хуваарьт Орхон аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгаанд зориулсан төсөв 32,5 сая төгрөг батлагдан орж ирсэн. Орхон аймгийн НДГ-ын даргын 2025.05.15-ны өдрийн А/21 тоот тушаалаар төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, хяналт тавих Үнэлгээний хороог 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж сонгон шалгаруулалтаар Орхон аймгийн ҮЭХ-ны ХАБЭА-н сургалтын байгууллага шалгарч гэрээ байгуулсан. Гэрээг 2025.12.28-ны өдрийн дотор дүгнэхээр ажиллаж байна.			
3	Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай 2025.07.23 №10		Даатгуулагчийн дэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.34% тогтоосугай.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 10 дугаар тогтоолыг ажилтан албан хаагчдад танилцуулж, “Нэрийн дансыг нээх бүртгэх хөтлөх даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ын талаар сургалт мэдээлэл өгч ажиллалаа. Дээрх тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой Сикос системд программын хөгжүүлэлт хийгдээгүй байна.	100%		
4	Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн		Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас	2025 оны 11 сард Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2 гишүүн НДЕГ-ын дэргэдэх ЭММТөв Зөвлөлийн дарга, магадлагч эмч нар Орхон аймагт ажиллаж, Эрдэнэт-сувилал цогцолборын үйл ажиллагаатай танилцан амрагч,	100%		

осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай 2025.07.23 №12	олгох хэмжээг нэг ор хоногт 110.000 төгрөгөөр тогтоосугай.	сувилуулагчидтай уулзан санал сэтгэгдэл сонссон. Манай зүгээс улирал бүр сувиллын үйл ажиллагаа, хоолны амт чанар, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийн талаар сэтгэл ханамжийн судалгаа гаргаж дүгнэлтийн талаар эргэж мэдээлэн хамтарч ажиллаж байна. Даатгуулагч нарт мэдээлэл хүргэсэн пост 1 удаа түгээж, ЭМГазар болон Эрдэнэт сувиллын цогцолборт албан тоотоор тогтоолыг хүргүүлсэн.		
Хэсгийн дундаж: 100 хувь				

Биелэлтийн товчоо

Д/д	Зорилт арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Үүнээс				Хэрэгжилтийн тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
			100% биелсэн	Хэрэгжих шатандаа				
				70%	30%	0%		
1.	Улсын их хурлын тогтоол	1						100%
2	УИХ—ын байнгын хорооны тогтоол	1						100%
3.	Засгийн газрын тогтоол	9						100%
4.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	10						100%
5.	Ерөнхий сайдын албан даалгавар, захирамж	6						100%
6.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	4						100%
Нийт 100%								

Хэрэгжилтийг хянасан:

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ.....

/Д.НАРМАНДАХ/

Хэрэгжилтийг нэгтгэн тайлагнасан:

ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

.....

/Д.ИДЭРЖАВХЛАН/

